



МОНГОЛ УЛСЫН КОНСЕРВАТОРИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/92

Улаанбаатар хот

Монгол Улсын Консерваторийн цалин хөлсний
журам батлах тухай

Монгол улсын "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн 101 дүгээр зүйлийн 1, 102, 104, 106, 109 дүгээр зүйлийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын Консерваторийн "Цалин хөлсний журам"-ыг хавсралтаар баталсугай.
2. "Цалин хөлсний журам"-ыг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.
3. Шинээр батлагдсан "Цалин хөлсний журам"-ыг нийт багш ажилтнуудад танилцуулахыг хүний нөөцийн менежерт даалгасугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ПҮРЭВХҮҮ



МОНГОЛ УЛСЫН КОНСЕРВАТОРИЙН ЦАЛИН ХӨЛСНИЙ ТУХАЙ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журмын зорилго нь Консерваторийн ажил, албан тушаалын ангилал, зэрэглэл, ур чадвар, ажилласан хугацаа, боловсролын болон эрдмийн зэрэг зэргийг харгалзан үндсэн цалин, нэмэгдэл цалин, нэмэгдэл хөлс, хөнгөлөлт урамшуулал олгохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү журам нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Консерваторийн дотоод журам болон бусад холбогдох дүрэм, журамд нийцсэн байна.
- 1.3 Журмын хэрэгжилтэд хөгжлийн бодлого, удирдлагын алба хяналт тавьж ажиллах ба Консерваторийн захирлын тушаалаар баталж, мөрдөх ба нэмэлт өөрчлөлт оруулж болно.

ХОЁР. ЦАЛИН ХӨЛСНИЙ ЖУРМЫН БАРИМТЛАХ СТРАТЕГИ, ЗАРЧИМ

- 2.1 Бодитой шударга байх
- 2.2 Нэгдмэл системтэй байх
- 2.3 Өндөр нууцлалтай байх; /Цалингийн сүлжээ, ажилтны цалин хөлсний хэмжээ байгууллагын болон хувь хүний нууцад хамаарагдана./
- 2.4 Багш, ажилтны цалинг Засгийн газрын тогтоолыг үндэслэн тогтмол болон хийснээр буюу хөдөлмөрийн үр дүнд тохируулсан / ажилтны ур чадварын түвшин, ажлын гүйцэтгэл, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулах/ хэлбэрээр олгодог байх
- 2.5 Адил хөдөлмөр эрхэлж байгаа эрэгтэй эмэгтэй ажилтанд адил хэмжээний цалин хөлс олгох
- 2.6 Цалин хөлсийг тооцох аргачлал ил тод, ойлгомжтой байх

ГУРАВ. ЦАЛИН ХӨЛС, ШАГНАЛ УРАМШУУЛАЛ, ТЭТГЭМЖ ТУСЛАМЖ

3.1 Цалин хөлс

3,1,1 Цалин хөлсийг тогтоосон хэмжээгээр, зохих нэмэгдлийн хамт сард 2 удаа сар бүрийн 10-11, 25-26-ны өдөр олгоно. **"...Ингэхдээ хоолны мөнгийг өдрийн 3000 төгрөг, унааны мөнгийг өдрийн 500 төгрөгөөр бодож сар бүр олгоно."** Холбогдох нэгж цалингийн тодорхойлолтыг ажлын 3 хоногийн өмнө хүний нөөцийн ажилтан, менежерүүд болон захирлаар батлуулан цалин хөлсний нягтлан бодогчид ирүүлнэ.

3,1,2 Ажилтны хүсэлтээр 1 сарын цалин хөлсийг урьдчилан олгож, дараа сарын цалингаас суутгана.

3,1,3 Ажлын шаардлагаар багш, ажилтныг амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр, илүү цагаар болон шөнийн цагаар ажиллуулсан бол хууль тогтоомжид нийцүүлэн нэмэгдэл хөлс, бусад нэмэгдлийг тухайн сард нь олгоно.

3.2 Нэмэгдэл хөлс

- 3.2.1 Илүү цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны тав дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно.
- 3.2.2 Ажилтанд үндсэн цалин дээр нь мэргэжлийн зэргийн, ур чадварын, үр дүнгийн нэмэгдлийг тогтоосон журмын дагуу олгож болох ба тусгайлсан дараах хэлбэрийн нэмэгдлүүд байж болно.
- Ажлын хүнд, хортой нөхцөлийг харгалзан зарим ажилтан /бохирын үйлчлэгч, слесарь, архивын ажилтан гэх мэт/-д үндсэн цалингийн 25 хүртэл хувь
 - Ур чадварын нэмэгдлийг үндсэн цалингийн 10-25 хувь, урамшууллыг ажлын бүтээмжийг харгалзан 1 хүртэл сарын үндсэн цалин олгож болно.
- 3.2.3 Ажил, албан тушаал хослон гүйцэтгэх, хослон ажиллах түр орлон ажиллах, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байранд заагаагүй ажил үүргийг гүйцэтгэсэн үед үндсэн цалингийн 40 хүртэл хувьтай тэнцэх нэмэгдэл хөлс олгоно.

3.3 Шагнал урамшуулал

- 3.3.1 Ажил үүргээ чанартай, өндөр түвшинд гүйцэтгэсэн, хариуцсан ажилдаа тодорхой амжилт гаргасан багш ажилтныг, захиргаанаас тогтоосон журмын дагуу шагнаж урамшуулах, төр засгийн болон бусад байгууллагын шагналд тодорхойлно.

3.4 Тэтгэмж, тусламж

- 3.4.1 Консерваторийн багш, ажилтан нас барсан тохиолдолд 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний буцалтгүй тусламж үзүүлж болно.
- 3.4.2 Ажилтны /төрсөн/ эцэг эх, эхнэр, нөхөр, өөрийн төрсөн үр хүүхэд нас барахад 200.000 төгрөг олгож болно.
- 3.4.3 Өвчний улмаас хөдөлмөрийн чадваргүй болсон гэр бүлийн гишүүнээ асарч, халамжлах, ар гэрийн гачигдалтай байдлыг харгалзан 150.000 /Нэг зуун тавин мянган/ төгрөгийн буцалтгүй мөнгөн тусламж үзүүлж болно.
- 3.4.4 Тэтгэвэрт гарсан ахмад настан ажилтан нас барсан тохиолдолд ар гэрт нь 100.000-400.000 төгрөгийн тусламжийг олгож болно.
- 3.4.5 Амьдралын хүнд нөхцөл, дахин давтагдашгүй хүчин зүйл, бэрхшээл тохиолдсон багш ажилтанд жилд 1 удаа тодорхой хэмжээний мөнгөн тусламж үзүүлж болно. Мөнгөн тусламжийн дүнг Захирлын зөвлөлөөр хэлэлцэж хүсэлт гаргасан шалтгаан, ажилтны ажилласан жил зэргийг харгалзан шийдвэрлэнэ.
- 3.4.6 Ажлын байр нь хадгалагдаж байгаа ажилтны оронд түр ажиллаж байсан ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болоход тэтгэмж олгогдохгүй.
- 3.4.7 Багш, ажилтанд хууль, тогтоомжийн бусад актад заасан хөнгөлөлт, нөхөн төлбөрийг олгоно.